# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/53 Алтай

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Энэ оны 02 дугаар сарын 10-ны өдөр явагдах нийтийн дуудлага худалдааг эрхлэн явуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хөтлөгч: С.Гантулга - Орон нутгийн өмчийн албаны дарга

Өмчийн төлөөлөгч: З.Мөнхнасан - Орон нутгийн өмчийн албаны мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Э.Лхагвадулам – Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2. Нийтийн дуудлага худалдааг зохих журмын дагуу ил тод нээлттэй явуулж, дүнг танилцуулахыг комисс /С.Гантулга/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

133

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 10 өдөр Дугаар А/54 Алтай

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИАРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2014 оны 02 сарын 09-ний 01/36 дугаар албан бичигт дурьдсан Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Д.Эрдэнэцогттой холбоотой асуудлыг шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Чинзориг –Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд: Ц.Оюунтуул –Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга

Р.Пүрэвдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

2. Албан бичигт дурьдсан асуудлыг судлан үзэж, дүгнэлт гаргаж, 02 сарын 13-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Чинзориг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

02 004181

134

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 10 өдөр    Дугаар А/55    Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2014-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2014 оны Үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах санал боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батсайхан – Иргэн-нийгмийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч дарга

Гишүүд: Д.Чинзориг – Эдийн засаг-дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч дарга

Х.Энхбаяр - ИТХ-ын Тэргүүлэгч /зөвшилцсөнөөр/

Б.Эрдэнэбаяр - Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

Д.Оттонбаяр - Хууль зүйн хэлтсийн дарга

М.Занданбилэг - Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Баянмөнх –Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Э.Буянтогс - Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Г. Лхагважаргал - Нэгдсэн эмнэлгийн зөвлөх эмч

Нарийн бичгийн дарга: Р.Цэнд-Аюуш -Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн Мэргэжилтэн

П.Баасан – Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Хөтөлбөрийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн цогц бодлого, улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Батсайхан/-д даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл боловсруулахад ажлын хэсгийг шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээллээр хангаж ажиллахыг нийт хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

02 000185

135

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 15 өдөр Дугаар А/56 Алтай

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 17 дугаар зүйлийн 17,1, 21 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15,3, Засгийн газрын 2004 оны 55 дугаар тогтоол, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 06 дугаар тушаалаар батлагдсан Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг 2014 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах аймгийн комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт хийх тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн хугацааг гуравдугаар, сумдад ажиллах хэсгийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

3. Техникийн хяналтын үзлэгийн хуваарь, бэлтгэл ажлын талаар тээврийн хэрэгсэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд урьдчилан мэдээлэл өгч, сурталчилахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга /Г.Түмэннасан/, аймаг дахь Авто тээврийн үндэсний төвийн дарга /М.Түндэв/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Албан журмын даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Х.Баатарзориг/, Албан журмын даатгагчдын холбооны салбарын захирал /Л.Мөнх-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

5. Сумын салбар комиссыг тухайн сумын Засаг дарга зохион байгуулан, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, татварын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй ажиллуулж Хавсралтад дурьдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийг үзлэгт бэлэн байлгах,

C:/My Documents/ZAHNR-3A-4doc

02 000260

үзлэгийн үеэр "Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль"-ийн дагуу даатгалын компаниудын үйл ажиллагаа явуулах байраар хангах, ажлын явцын мэдээ тайланг холбогдох байгууллагуудад сар тутам мэдээлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтоосон хувь хэмжээний дагуу хугацаанд нь хураах төвлөрүүлэх ажлыг аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Батбаяр/-т үүрэг болгосугай.

7. 2014 оны Техникийн хяналтын үзлэг хугацаандаа хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын стандарт шаардлагыг хангуулж, замын хөдөлгөөнд оролцуулахгүй хязгаарлаж байхыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга /Г.Түмэннасан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2014 оны
04 дугаар сарын 13-ны өдрийн 1/6 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

# ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ КОМИССЫН АЖЛЫН УДИРДАМЖ

Техникийн хяналтын үзлэгийн зорилго:

Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 55 дугаар тогтоол болон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандартыг хангуулах, замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга дэг журам, соёлыг дээшлүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Хяналтын үзлэг хийх бүрэлдэхүүнд орох байгууллагууд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Говь-алтай аймаг дахь Автотээврийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын газар ,Татварын хэлтэс, Даатгалын компаниудтай хамтран хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.

Техникийн хяналтын үзлэг хийх үе шат , гүйцэтгэх ажил:

1. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогоонд бүрэн хамруулах.
2. Байгууллага, аж ахуйн нэгж ,иргэдийн өмчлөгч тээврийн хэрэгслийг бүртгэлийн нэгдсэн сүлжээнд оруулах .
3. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар оношлогооны хураамж төлсөн баримтыг үндэслэн тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт хамруулах.
4. Орон нутгийн нийтийн зорчигч тээвэр, нийтийн такси үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллах,
5. Орон нутагт тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогооны явц, байдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчилах стандартын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулж дахин шалгаж албан байгууллагын удирдлагуудад нь шаардах хуудас, мэдэгдэл өгөх, хариуцлага тооцох зэрэг ажилуудыг чанартай хийх .
6. Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогоо, тооллогын ажлын дүн мэдээг техникийн хяналтын үзлэг явуулах бүрэлдэхүүнээр сумын Засаг даргад танилцуулна. Сумын үзлэгийн комисс үнэлгээ өгч 2014 оны нэгдсэн тайлан гаргаж аймгийн Засаг даргад танилцуулах.

---оОо---

Аймгийн Засаг даргын 2014 оны
02 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: - Аймгийн засаг даргын орлогч

Комиссын нарийн бичгийн дарга: - Аймаг дахь Автотээврийн үндэсний төвийн дарга

Гишүүд:

- Аймгийн Татварын хэлтсийн дарга
- Аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга
- Аймгийн Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасгийн дарга
- Авто тээврийн улсын байцаагч
- Сумдын Засаг дарга нар
- Албан журмын даатгагчдын холбооны салбарын захирал

— oOo —

134

Аймгийн Засаг даргын 2014 оны
04 дугаар сарын 13 -ны өдрийн 2 дугаар
захирамжийн тувээдугаар хавсралт

АЙМГИЙН ТӨВ БОЛОН ЕСӨНБУЛАГ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
2014-ОНД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЗЛЭГ ОНОШЛОГОО ЯВУУЛАХ
ХУВААРЬ

| № | Байгууллага, аж ахуйн нэгж, багууд | Хамрагдах хугацаа | Тээврийн хэрэгслийн тоо | Ажиллах бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|
| 1. | Тэлш алтай | 02 сарын 24 | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 2. | Ихэс алтай | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 3. | БХТНийгэмлэг | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 4. | Хан буурал | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 5. | МСҮТ | | 7 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 6. | Мөнх жолоо | | | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 7. | Нэгдсэн эмнэлэг | 02 сарын 26 | 10 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 8. | Энэрэл Алтай өрхийн эмнэлэг | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 9. | Марал Алтай өрхийн эмнэлэг | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 10. | Энх Алтай өрхийн эмнэлэг | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 11. | Жаргалант Алтай өрхийн эмнэлэг | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 12. | Онцгой байдлын алба | | 10 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 13. | Цагдаагийн хэлтэс | 02 сарын 26 | 18 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 14. | Аймгийн ИТХ | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 15. | Нийтлэг үйлчилгээ | | 10 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 16. | Аудит | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 17. | МХГазар | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 18. | Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 19. | Газрын харилцаа хот байгуулалтын алба | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 20. | Байгаль орчны алба | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 21. | Нийгмийн даатгалын хэлтэс | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 22. | Есөнбулаг сумын ЗДТГ | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 23. | Хан тайшир эрдэм цогцолбор | 02сарын 27 | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 24. | 1-р сургууль | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 25. | 2-р сургууль | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 26. | Шүүхийн шийдвэр гүйцэттэх алба | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 27. | Аймгийн шүүх | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 28. | Аяны зам хоршоо | 03-сарын03 | 32 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 29. | Шүүхийн шинжилгээний алба | 03сарын 04 | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 30. | Прокурорын газар | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 31. | Тагнуулын хэлтэс | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 32. | Биеийн тамир спорт хороо | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 33. | Радио өрген нэвтрүүлгийн станц | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 34. | Анагаах ухааны коллеж | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 35. | Монгол банк | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 36. | Хаан банк | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 37. | Төрийн банк | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 38. | Хас банк | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 39. | Цахилгаан холбооны газар | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 40. | Мэдээлэл холбооны сүлжээ | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 41. | Шуудан үйлчилгээний газар | | 5 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 42. | Есөнбулаг эрчим хүч | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 43. | Алтай улиастай ххк | 03 сарын 05 | 6 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 44. | Тайшир гүүлин усан цахилгаан станц | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 45. | Нийгмийн эрүүл мэндийн төв | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 46. | Гаалийн газар | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 47. | Монгол дээттэл | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 48. | Алтай чуулга | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 49. | Магнай трейд ххк | | 6 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 50. | Монсуль | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 51. | Нефть хангамжийн бааз | | 12 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 52. | Газар хөдлөлийн станц | 03 сарын 07 | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 53. | БГХӨТГазар | | 5 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 54. | Стандарт хэмжил зүйн газар | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 55. | Нисэх буудал | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 56. | АТҮТөв | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 57. | ХХААГазар | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 58. | Тохижилт үйлчилгээний газар | 03 сарын 10 | 10 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 59. | Ус Алтай ххк | | 11 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 60. | Ус цаг уур | | 4 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 61. | Дэлхийн зөн олон улсын байгууллага | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 62. | Мерси кор | 03сарын 12 | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 63. | Норвегийн туслам-жийн байгууллага | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 64. | Ентум ххк | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 65. | Боловсрол соёлын газар | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 66. | Тулга Алтай ххк | | 10 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 67. | Мандал голомт ххк | | 5 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 68. | Монгол ардын намын хороо | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 69. | Улаан загалмайн хороо | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 70. | Үндрэм оюу ххк | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 71. | Цэм сүргийн аж ахуй | | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 72. | Эрдэнэт хивс | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 73. | Шинэ Алтай ххк | 03сарын 14 | 2 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 74. | Татварын хэлтэс | | 3 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 75. | Харшийн цуурай | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 76. | АЗЗА ХХК | | 15 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 77. | Айргийн хад | | | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 78. | Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар | | 1 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 79. | Баян хайрхан баг | 03сарын 17-21 | 350 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 80. | Баян шанд баг | 03сарын 24-28 | 314 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 81. | Хараат баг | 03сарын31-04сарын 08 | 380 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 82. | Жаргалант баг | 04сарын 09-15 | 214 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 83. | Рашаант баг | 04сарын 21 | 138 | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |
| 84. | Наран баг | 04сарын 23 | | Авто тээврийн үндэсний төв "Алтай " салбар |

Тайлбар : Энэ хавсралтанд бичигдээгүй шинээр бий болсон ба шилжиж ирсэн аж ахуй нэгж, Байгууллага иргэд нь багийн харъяаллын дагуу хуваарт өдрөө оношлогоонд хамрагдах болно.

— oOo —

Аймгийн Засаг даргын 2014 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн [illegible] дугаар
захирамжийн дугаар хавсралт

## СУМДЫН ҮЗЛЭГ ОНОШЛОГОО ХИЙХ БҮРЭЛДЭХҮҮН, МАРШРУТ, ҮЗЛЭГ ХИЙХ ХУГАЦАА

### 1-р чиглэл

| № | Техникийн хяналт, онош-логоо явуулах сум багийн нэр | хугацаа | Хоорондын зай км | Хамрагдах тх-н тоо | Аймгаас ажиллах бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гуулин тосгон | 04 сарын 28 | 80 | 215 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 2 | Дэлгэр сум | 04 сарын29 | 30 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 3 | Чандмань сум | 05 сарын 01 | 150 | 253 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 4 | Эрдэнэ сум | 05 сарын 03 | 35 | 171 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 5 | Гэгээт баг | 05 сарын 05 | 70 | 25 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 6 | Баянтоорой тосгон | 05 сарын 06 | 100 | 79 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 7 | Цогт сум | 05 сарын 08 | 90 | 253 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 8 | Бигэр сум | 05 сарын 10 | 87 | 144 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 9 | Алтай хотод ирэх | 05 сарын 12 | 110 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, тех-никч, бүртгэлийн мэргэжилтэн касс |

### 2-р чиглэл

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Олонбулаг баг | 05 сарын 15 | 85 | 139 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 2 | Халиун сум | 05 сарын 16 | 50 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 3 | Цээл сум | 05 сарын 18 | 85 | 253 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Алтай сум | 05 сарын 20 | 225 | 213 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 5 | Тахийн тал | 05 сарын 22 | 280 | 40 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 6 | Хар толгой баг | 05 сарын 23 | 60 | 25 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 7 | Бугат сум | 05 сарын 24 | 30 | 294 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 8 | Төгрөг сум | 05 сарын 26 | 60 | 237 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс улсын байцаагч |
| 9 | Алтай хотод ирэх | 05 сарын 28 | 146 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |

3-р чиглэл

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Шарга сум | 06 сарын 02 | 85 | 220 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 2 | Тонхил сум | 06 сарын 04 | 125 | 224 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 3 | Дарви сум | 06 сарын 06 | 38 | 233 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 4 | Хар эрэг баг | 06 сарын 08 | 80 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 5 | Хөх-морьт сум | 06 сарын 09 | 110 | 100 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| 6 | Баян-уул сум | 06 сарын 10 | 78 | 345 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 7 | Жаргалан сум | 06 сарын 13 | 75 | 166 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |
| 8 | Тайшир сум | 06 сарын 15 | 78 | 235 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн касс |
| 9 | Алтай хотод ирэх | 06 сарын 17 | 45 | | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер техникч, бүртгэлийн мэргэжилтэн, касс |

4-р хүснэгт

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Марко поло /уурхай/ | 08сарын 25 | 120 | 60 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |
| | "Алтайн хүдэр" /Таян нуурын уурхай / | 07сарын 03 | 220 | 440 | ГАА дахь Автотээврийн үндэсний төвийн оношлогч инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн ,касс |

Тайлбар : Энэ хавсралтанд бичигдээгүй шинээр бий болсон ба шилжиж ирсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь бүсийн харьяаллын дагуу хуваарьт өдрөө оношлогоонд хамрагдах болно.

___ oOo ___

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 03 сарын 17 өдөр Дугаар А/57 Алтай

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2013 оны А/373, А/404, 2014 оны А/47, А/52 дугаар захирамжуудыг хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн хэлтэс /Д.Отгонбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /А.Мөнхтөр/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

02 000217

117

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 09 сарын 17 өдөр Дугаар 1/08 Алтай

## Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших хүсэлт гарган аймгийн Засаг даргын захирамжаар газар эзэмших эрх авсан хавсралтад заагдсан нэр бүхий 22 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн нэгж талбарт газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Дээрх нэгж талбар газарт газар эзэмших эрх нь цуцлагдсан 22 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 21 хоногийн дотор албан ёсоор эрх нь цуцлагдсан мэдэгдлийг хүргүүлж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /А.Мөнхтөр/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

02 000211

Аймгийн Засаг даргын 20[illegible] оны [illegible]-сарын [illegible]-ны өдрийн [illegible] тоот захирамжийн хавсралт

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙГ НЬ ЦУЦАЛЖ БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НЭРС

| № | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр | Байршил | Газрын хэмжээ /м2/ | Зориулалт | Авч олгосон захирамжийн дугаар /огноо/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Г.Пүрэвлил | Баянхайрхан баг 20-р байрны урд талд | 96 | Орон сууц | 2007.06.27/155 |
| 2 | Лозовын Буяндалгар | Харзат баг 6-р цэцэрлэгийн баруун талд | 128 | Орон сууц | 2008.05.08/151 |
| 3 | Борисын Амарсайхан | Харзат баг6-р цэцэрлэгийн баруун талд | 300 | Орон сууц Ахуйн | 2008.05.08/151 |
| 4 | Ванжил Сүррагчаа | Баянхайрхан баг Шинэ хорооллын зүүн талд | 480 | Граж | 2008.05.08/151 |
| 5 | Нямхүүгийн Довчин | 6-р цэцэрлэгийн урд талд | 300 | Орон сууц | 2008.05.08/151 |
| 6 | Б.Давгадорж | Харзат баг аймгийн Гаалийн хорооны урд талд | 96 | Орон сууц | 2008.08.22/262 |
| 7 | Д.Энхтөр | Харзат баг аймгийн Гаалийн хорооны урд талд | 96 | Орон сууц | 2008.08.22/262 |
| 8 | Р.Гомбодорж | Харзат баг аймгийн Гаалийн хорооны урд талд | 96 | Орон сууц | 2008.08.22/262 |
| 9 | Н.Хонинхүү | Харзат баг аймгийн Гаалийн хорооны урд талд | 96 | Орон сууц | 2008.08.22/262 |
| 10 | Ш.Энхболд | Харзат баг аймгийн Гаалийн хорооны урд талд | 96 | Орон сууц | 2008.08.22/262 |
| 11 | Баттөмөр Амартүвшин | Харзат баг Монгол даатгалын хойд талд | 310 | Үйлчилгээ | 2008.09.01/267 |
| 12 | Орон нутгийг судлах Музей | Баянхайрхан баг Эм хангамжийн зүүн талд | 2000 | Төрийн Үйлчилгээ | 2008.09.24/281 |
| 13 | Равжүүгийн Буяндалгар | Харзат баг хуучин Сурьеэгийн эмнэлэгийн зүүн талд | 12000 | Үйлдвэр | 2008.09.25/286 |
| 14 | "Намалзахын хишиг" хоршоо | Баяншанд баг Енгүм ХХК-ний үйлдвэрийн хойд талд | 4200 | Хийн түлшний үйлчилгээ | 2009.03.18/72 |
| 15 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба | Харзат баг "Алтай Баян" ХХК-ний халуун усны урд талд | 2500 | Албан контор | 2009.07.01/182 |
| 16 | "Залуур-Алтай" ХХК | Баяншанд баг Хуучин Дулааны станцын баруун хойд талд | 5390 | Граж, зоорь, үйлдвэрлэл | 2009.07.01/182 |
| 17 | Эрдэнэдалай Пүрэвжав | Баяншанд багийн Түүхий эдийн "Нэг" захын зүүн хойд талд | 2500 | Үйлчилгээ | 2009.09.08/258 |
| 18 | Аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг | Баянхайрхан баг, 40 жилгийн өндөрлөгийн зүүн талд, Хүүхдийн ордны шинэ барилгын дэргэд | 394.24 | Албан контор | 2011.03.14/87 |
| 19 | Монгол Ардын намын хороо | Баянхайрхан баг Монгол Ардын Намын хорооны баруун талд | 400 | Намын байгууллага | 2011.05.06/171 |
| 20 | Пэрсиммон ХХК | Рашаант баг Хуучин чулууны үйлдвэрийн зүүн талд | 20000 | Тэсрэх материал хадгалах төвөөрөх | 2011.10.19/322 |
| 21 | Монцуухир ХХК | Жаргалант баг Хийдийн урд талд | 403.2 | 30 айлын орон сууц | 2011.10.19/330 |
| 22 | 100 мянган айл орон сууц хөтөлбөрт | Баянхайрхан баг 11 дүгээр гудамжны хойд талд | 505035 | Орон сууц | 2011.10.19/331 |

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 02 сарын 18 өдөр Дугаар А/19 Алтай

### Гадаадад томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, тайлан гаргах журмын 3.1, 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчён хотноо тус улсын Хөдөлмөрийн яамны харьяа "Аж үйлдвэр, хүний нөөцийн агентлаг"-аас зохион байгуулж буй "Удирдлагын түвшний хүний нөөцийн сургалт"-д аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга М.Ууган-Эрдэнийг 2014 оны 02 сарын 23-ны өдрөөс оролцуулсугай.

2. Хуралд оролцоход шаардагдах зардлыг хавсралтын дагуу тооцож, аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгийн гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Эрдэнэцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:My documents\a ... А-4 doc

02 000195

Аймгийн Засаг даргын 2014 оны
02 дугаар сарын 12-ны өдрийн А/59 дугаар
захирамжийн хавсралт

## ЗАМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын утга | Зардлын хэмжээ | Нийт зардал |
|---|---|---|---|
| 1. | Замын зардал /Улаанбаатар-БНСУ-ын Инчён хот/ | 2250$ | 3 937 500 |
| 2. | Томилолтын зардал | 2 Хоног /150$* 2=300$/ | 525000 |
| 3. | Нийт зардал | 2550$ | 4462500 |

Жич: Өнөөдрийн байдлаар Монгол банкны ханш доллар 1750 төгрөг

---oOo---

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 18 өдөр Дугаар А/60 Алтай

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.3, Үнэлгээний хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ЭЭХ-14/01 дугаартай 1, 2, 3, 5, 7 дугаар багцыг Монгол эм импекс концерн ХХК-тай, 4, 6, 15 дугаар багцыг "Монос фарм Трейд" ХХК-тай, 22 дугаар багцыг "Пролианс" ХХК-тай тус тус гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар /Т.Ганболд/-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн нийлүүлэхээр санал болгосон барааны тоо, хэмжээ, чанар, нийлүүлэх хугацаа, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгах, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Т.Ганболд/-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Х.Баатарзориг/, Нийгмийн хөгжлийн хэлтэс /С.Цагаанбаатар/ Мэргэжлийн хяналтын газар /Ч.Амарсанаа/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZD A-4doc

02 000239